



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 2/51

Цагаантолгой

2022 оны авто тээврийн хэрэгслийн техникийн
Улсын үзлэг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.10, 59.1.23, Авто тээврийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.3.1, 19.3.2 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28-р зүйлийн 28.1.1, 28.1.10, 28.1.12, архитан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14-р зүйлийн 14.3, 14.4 дэх заалт, Засгийн газрын “Автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах давтамж, оношилгооны төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 2016 оны 213 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны А/09 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 оны авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын Улсын үзлэг сумын хэмжээнд 2022 оны 05 дугаар сарын 01, 02 – ны өдөр зохион байгуулагдахтай холбоотойгоор үзлэг явуулах бэлтгэл ажлыг хангах, удирдан зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдхүүнтэйгээр байгуулсугай. .

Ажлын хэсгийн ахлагч - Б.Мөнх-Эрдэнэ – (Засаг даргын орлогч)

Гишүүдэд – Б.Наранцэцэг – (Татвар хураагч)

Л.Сэлэнгэсайхан – (Ивэн багийн Засаг дарга)

Б.Золбаяр – (Хушаат багийн Засаг дарга)

Ч.Төгсбаатар – (Байгаль хамгаалагч)

Н. Лхагважаргал – (Хэсгийн төлөөлөгч)

Ч.Дэлгэрцогт - (Хэсгийн цагдаа)

2.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын Улсын үзлэгийг сумын хэмжээнд удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж, иргэд аж ахуйн нэгж байгууллагад сурталчлан мэдээллэх, тээврийн хэрэгслийг бүрэн хамруулах арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3.Улсын үзлэг явагдаж байгаатай холбогдуулан гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор 2022 оны 05 дугаар сарын 01, 02 – ны өдрүүдэд согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

4.Улсын үзлэгийн хэрэгжилтийн дүнг Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: Б. Нарангэрэл
Хянасан: С. Шатирбаатар
Хувь: 2
Огноо: 2022.04.29